



- Эдлэлийн хэсгийг огтлож, огтлолд үүссэн дүрсийг дурын байрлалд дүрслэн харуулах аргыг сонгоно уу.
 А. шилжүүлсэн огтлол
 В. дунд нь дүрслэх огтлол
 С. давхцуулсан огтлол
 D. дээр давхцуулах огтлол
- Аливаа эдлэлийг зохион бүтээхдээ түүний хэлбэр, хэмжээ, өнгө, материал, чимэглэлийг тодорхой аргуудын тусламжтайгаар нэгтгэн нэгэн цогц болгосон шийдлийг сонгоно уу.
 А. дизайн
 В. загвар
 С. технологи
 D. зохиомж
- Бүтээгдэхүүний хэлбэр хэмжээний зохион бүтээлтэд ашигладаг алтан харьцааг сонгоно уу.
 А. 1:2
 В. 1:1.5
 С. 1:1.618
 D. 1:3
- Модон материалын огтлолыг дүрсэлсэн тэмдэглэгээг харуулсан зургийг сонгоно уу.




A.



B.





C.




D.


- Зурагт үзүүлсэн деталийг огтлогч В хавтгайгаар огтлоход үүсэх дүрсийг зөв дүрсэлсэн зургийг сонгоно уу.




A.



B.




C.




D.

- Зурагт үзүүлсэн деталийн ажлын зурагт сумаар заасан огтлолыг дүрсэлсэн аргыг сонгоно уу.



- дурын зайд шилжүүлэх
- проекц дээр давхцуулах
- хавтгайн мөрийн дагуу шилжүүлэх
- проекцыг таслан дундах зайд давхцуулах

7. Зурагт үзүүлсэн зүсэлтийн дүрслэлүүдийг нэршилтэй нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.





a. нүүрний зүсэлт



b. хажуугийн зүсэлт

c. хэвтээ зүсэлт


- A. 1-с, 2-b, 3-a B. 1-a, 2-b, 3-с C. 1-b, 2-a, 3-с D. 1-с, 2-a, 3-b
8. Тэгш өнцгийн проекцын хажуугийн проекцыг зөв дүрсэлсэн зургийг сонгоно уу.




9. Зурагт үзүүлсэн деталийн 1/4 зүсэлтийн тэгш өнцгийн проекцыг зөв дүрсэлсэн зургийг сонгоно уу.




A.



B.



C.




D.

10. Оёдлын машины алхам тохируулагчийн хэмжээг өөрчлөхөд юу өөрчлөгдөх вэ? Зөв хариуг сонгоно уу.


- А. оёдлын чанга сул
 В. машины дарагч ул
 С. оёдлын алхмын хэмжээ
 D. улны утасны хэмжээ

11. Хөвөн даавуун баривч индүүдэхэд аль тохиргоо тохиромжтой вэ?




12. Дээл (баривч)-ийн эсгүүрийг байгуулахын тулд хүний биеэс авдаг хэмжээнүүдийг сонгоно уу.

- А. хүзүүний тойрог, цээжний тойрог, дээлийн урт, ханцуйны урт, бугуйн тойрог
 В. хүзүүний тойрог, бэлхүүсний тойрог, суудлын өндөр, ханцуйны урт, өгзөгний тойрог
 С. цээжний тойрог, бэлхүүсний тойрог, өгзөгний тойрог, дээлийн урт, ханцуйны урт
 D. ханцуйны урт, хүзүүний тойрог, дээлийн урт, бэлхүүсний тойрог, бугуйн тойрог
13. Зурагт үзүүлсэн дээл (баривч)-ийг эсгэх аргыг зөв нэрлэсэн хариуг сонгоно уу.




- А. ухаж эсгэх
 В. зөрүүлдэж эсгэх
 С. ташаалдаж эсгэх
 D. гүйлгэж эсгэх

14. Дээл зөрүүлдэж эсгэхэд даавууг зөв нугалах аргыг харуулсан зургийг сонгоно уу.




15. Дээл (баривч)-ны захны ухлаадасны хэвийг байгуулахад тойргийн радиусыг тооцоолдог томъёог сонгоно уу.




- A. $R = T_x/4$
B. $R = T_x/8$
C. $R = T_{ц}/4$
D. $R = T_6/8$

16. Зурагт үзүүлсэн эмжээрийг хэмнэлттэй бэлтгэх аргыг зөв нэрлэсэн хариуг сонгоно уу.




- A. орой эмжээр бэлтгэх арга
C. хошуу эмжээр бэлтгэх арга
B. гурвалжин эмжээр бэлтгэх арга
D. дөрвөлжин эмжээр бэлтгэх арга

17. Дээлийг нэг эмжих технологийн схем зургийг зөв тайлбарласан хариуг сонгоно уу.



- A. 1-эмжээрийг өнгө талд барьж оёно, 2-цаваг наана, 3-эмжээрийг ар тал руу давуулан унагаж индүүднэ, 4-хажлага болон дотор оёно
B. 1-цаваг наана, 2-эмжээрийг өнгө талд барьж оёно, 3-эмжээрийг ар тал руу давуулан унагаж индүүднэ, 4-хажлага болон дотор оёно
C. 1-эмжээрийг өнгө талд барьж оёно, 2-эмжээрийг ар тал руу давуулан унагаж индүүднэ, 3-хажлага болон дотор оёно, 4-цаваг наана
D. 1-хажлага болон дотор оёно, 2-цаваг наана, 3-эмжээрийг ар тал руу давуулан унагаж индүүднэ, 4-эмжээрийг өнгө талд барьж оёно

18. Зурагт үзүүлсэн оёдлын схем зургийг зөв нэрлэсэн хариуг сонгоно уу.



- A. нэгтгэж оёх
- B. нэгтгэж оёод хагалж индүүдэх
- C. нэгтгэж оёод унагаж индүүдэх
- D. нэгтгэж оёод хүрээ гаргаж индүүдэх


19. Баривч оёх технологийн үе шатуудыг зурагтай нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

1. дотрыг эсгэж оёх


2. сугалах

3. хавах


4. зах бэлтгэж залгах




a.



b.




c.



d.

- A. 1-a, 2-c, 3-d, 4-b B. 1-b, 2-a, 3-c, 4-d C. 1-c, 2-b, 3-a, 4-d D. 1-a, 2-b, 3-d, 4-c

20. Зурагт үзүүлсэн сампин зангидах аргачлалыг зөв дараалалд оруулсан хариуг сонгоно уу.




- A. a, b, c, d, e, f B. c, b, d, f, e, a C. f, c, b, a, d, e D. d, e, c, a, b, f

21. Зүймэл урлалын тэгш хуваалттай блокийн зохиомж гаргахад ямар дүрсүүдийг ихэвчлэн ашигладаг вэ?

- A. тэгш өнцөгт, квадрат, олон өнцөгт
 B. адил талт гурвалжин, тэгш өнцөгт, квадрат
 C. адил талт гурвалжин, дугуй, тэгш өнцөгт
 D. квадрат, гурвалжин, конус

22. Блок зохиомж ашиглаагүй зүймэл бүтээлийг сонгоно уу.



A.

B.

C.

D.

23. Зурагт үзүүлсэн зүймлийн үндсэн блокны давтамжийн тоог сонгоно уу.



- A. 2
- B. 3
- C. 4
- D. 12

24. Гэрийн нөхцөлд цагаан идээг уламжлалт аргаар боловсруулахдаа сав суулгыг хэдээс дээш хэмийн халуун усаар угааж ариутгах шаардлагатай вэ?

- A. 40° C-ээс дээш халуун ус
- B. 50° C-ээс дээш халуун ус
- C. 60° C-ээс дээш халуун ус
- D. 70° C-ээс дээш халуун ус

25. Тараг бүрэх технологийг гүйцээж, цэгийн оронд тохирох хариуг сонгоно уу.

1. Сүүг буцалгана.
2.
3. Хөрөнгө хийнэ.
4.
5. 35°-40°С дулаанд 2-4 цаг хөдөлгөхгүй тавина.
6. Бүрэлдсэний дараа сэрүүн газар шилжүүлэн тавина.

- | | |
|-------------------------------------|---------------------------|
| A. 2. Дахин буцалгана. | 4. Шар сүү хийнэ. |
| B. 2. Сүүг 40°-45°С хүртэл хөргөнө. | 4. Сайтар хутган самарна. |
| C. 2. Аарц хийнэ. | 4. Сайтар хутган самарна. |
| D. 2. Шар сүү хийнэ. | 4. Дахин буцалгана. |